

# Төлбөр төлөх аргачлал

## Ажилтны тэтгэврийн болон бусад даатгалын шимтгэл

### Даатгалын шимтгэл төлөх тухай ерөнхий мэдээлэл

Японы Тэтгэврийн Үйлчилгээний Газар (JPS)-ын харьяа салбарууд нь Ажиллагсдын Тэтгэврийн Даатгал (EPI) болон Ажиллагсдын Эрүүл Мэндийн Даатгал (EHI)-ын шимтгэлийг хураан төвлөрүүлдэг байгууллага юм. Ажил олгогч нь хуулийн дагуу, өөрийн болон даатгуулагч ажилтнуудын (ажил олгогч өөрөө орно) сарын цалин, урамшууллаас суутгасан нийт шимтгэлийн дүнг тогтоосон хугацаанд бүрэн төлөх үүрэгтэй. Сарын шимтгэлийг дараагийн сарын сүүлчийн өдөр төлнө. Тухайлбал, 4-р сарын шимтгэлийг 5-р сарын сүүлчийн өдөр төлнө. Хэрэв тухайн сарын сүүлийн өдөр амралтын өдөр таарвал, төлбөрийн хугацаа дараагийн ажлын эхний өдөрт шилжинэ.

Ажил олгогч нь ажилчдын тухайн сарын цалингаас шимтгэлийг (ажилчны хувь) суутгахдаа өмнөх сарын стандарт сарын цалин (SMR)-д нь үндэслэн тооцдог. Жишээ нь, таны 4-р сарын шимтгэлийг 5-р сард авах цалингаас нь суутгана. Ажилчдын урамшууллаас, Стандарт урамшууллын дүн (SBA)-гээр тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийг тооцон суутгана.

Сар бүрийн 20-ны орчимд, JPS-ээс ажил олгогчдод төлбөрийн мэдэгдэл (нэхэмжлэх), тухайлбал, "Шимтгэл төлөх тухай мэдэгдэл" эсвэл "Шимтгэл төлөх болон хүлээн авсан баримтын мэдэгдэл"-ийг илгээнэ. Даатгалын шимтгэлийн хэмжээг ажил олгогчийн өмнө нь ирүүлсэн, ажилтны даатгалд хамрагдсан эсвэл хасагдсан даатгуулагчийн Стандарт сарын цалингийн хэмжээ (SMR) болон Стандарт урамшууллын хэмжээ (SBA)-ний талаарх мэдээлэлд үндэслэн тооцоолно.

Анхаарна уу: Хэрэв та шуудангийн хаяг шилжүүлэх үйлчилгээ ашигладаг бол хүргэлт саатах магадлалтай. Шаардлагатай тохиолдолд, тухайлбал, төлбөрийн мэдэгдэл дахин авах зэрэг асуудлаар холбогдох бол \*<sup>1</sup> JPS-ийн холбогдох салбарт хандана уу.

\*<sup>1</sup> салбар гэдэг нь тухайн бүс нутгийн үйл ажиллагааг хариуцан явуулдаг салбар юм.

### Даатгалын шимтгэл хэрхэн төлөх вэ?

Та (ажил олгогч) даатгалын шимтгэлээ дараах хэлбэрээр төлөх боломжтой:

Банкны дансаар автоматаар төлөх

Банкны дансаар мөнгө шилжүүлэх үйлчилгээнд хамрагдахын тулд та дараах алхмуудыг хийх шаардлагатай:

- (1) Таны банк \*<sup>2</sup> "Ажиллагсдын Тэтгэврийн Даатгал (EPI) эсвэл Үндэсний Тэтгэврийн Даатгалын шимтгэлийг дансаар хүлээн авдаг банкуудын жагсаалт"-д байгаа эсэхийг шалгана уу. Үүнийг баталгаажуулахын тулд өөрийн харилцагч банкнаасаа энэ үйлчилгээг санал болгодог эсэхийг лавлаж болно.
- (2) Банкны дансаар автоматаар төлбөр шилжүүлэх хүсэлтийн маягыг бөглөнө үү.
- (3) Өргөдөлд оруулсан банкны мэдээлэл зөв эсэхийг баталгаажуулахын тулд харилцагч банкаараа шалгуулна уу.\*<sup>3</sup>
- (4) Өргөдлөө холбогдох Японы Тэтгэврийн Үйлчилгээний Газар (JPS)-т эсвэл салбарт шуудангаар илгээнэ үү. Мөн та өргөдлөө JPS-ийн салбарт өөрийн биеэр очиж өгөх боломжтой.

\*<sup>2</sup> Корпорац банк (эсвэл бусад хуулийн этгээд)-ийн хувьд тухайн байгууллагын нэр дээрх банкны данс байна.

\*<sup>3</sup> Хэрэв та зөвхөн онлайнгаар үйл ажиллагаа явуулдаг банк ашиглавал (3) дугаар алхмыг хийх шаардлагагүй.

## 2. Банкаар дамжуулан төлбөр хийх

“Шимтгэл төлөх мэдэгдэл”-ээр банкаар дамжуулан төлбөрөө хийж болно. (Мэдэгдлийг урж, гэмтээж болохгүй.)

## 3. Цахим Онлайн төлбөр (Pay-easy)

Цахим төлбөр хийхэд шаардлагатай дугааруудыг “шимтгэл төлөх мэдэгдэл”-ээс харна уу. Үүнд, хүлээн авах байгууллагын дугаар нь 00500, төлбөрийн дугаар нь 16 оронтой, баталгаажуулах дугаар нь 6 оронтой байна.

Эдгээр мэдээллийг шаардлагын дагуу бөглөж, төлбөрөө хийнэ үү.

- **Интернэт банк** - Интернэтээр төлбөр хийх
- **Мобайл банк** - Гар утсаар төлбөр хийх
- **АТМ (Pay-easy үйлчилгээгээр)** — Банкуудын АТМ дээр төлбөр хийх
- **Утсаар банкны үйлчилгээ** — Утасны зааварчилгаагаар төлбөр хийх

### Анхаарах зүйлс

- Интернэт банк, мобайл банк, эсвэл телефон банк ашиглахын тулд та төлбөр хийх банктайгаа цахим төлбөр тооцооны гэрээг урьдчилан байгуулсан байх шаардлагатай.
- JPS цахим төлбөрийн систем нь жилд 365 өдөр, 24 цагийн турш ажилладаг. Системийн засвар үйлчилгээнээс шалтгаалан үйлчилгээ түр ажиллахгүй тохиолдолд, энэ тухай мэдээллийг та манай цахим хуудаснаас үзэх боломжтой.
- Цахим төлбөрөөр төлбөр хийхэд баримт олгогдохгүй болохыг анхаарна уу. Хэрэв танд баримт зайлшгүй хэрэгтэй бол төлбөрөө банкинд хийх шаардлагатай болно.

## Шимтгэл төлөх нэхэмжлэх (инвойс)

Японы Тэтгэврийн Үйлчилгээний Газар (JPS)-ын салбарууд сар бүр танд "Шимтгэл төлөх нэхэмжлэх"-ийг илгээх бөгөөд үүнд ажиллагсдын тэтгэврийн даатгал, эрүүл мэндийн даатгал, далайчдын даатгал болон хүүхэд, хүүхэд асрах сангийн шимтгэл зэрэг сарын төлбөрүүд багтсан байдаг.

Нэхэмжлэлийн загвар жишээг доороос харна уу.

Банкаар шимтгэлээ төлөхдөө нэхэмжлэхийн иж бүрдэл бүрэн бүтэн байх шаардлагатай. Хэсэгчлэн салгаж болохгүй.

Шимтгэл төлөх нэхэмжлэхийн загвар (нэхэмжлэх)

2025 оны 3-р сарын байдлаар (цаашид өөрчлөгдөж болзошгүй)

- 1 “Төлбөрийн баримт”
- 2 “Төлбөрийн баримтын хуулбар”
- 3 “Шимтгэл төлөх нэхэмжлэл”

Анхаарна уу: JPS-ийн салбарууд сар бүрийн 20-ны орчимд танд нэхэмжлэх илгээх болно. Хэрэв та шуудангийн хаяг шилжүүлэх үйлчилгээ ашигладаг бол хүргэлт саатах болзошгүй. Хэрэв нэхэмжлэхээ дахин авах шаардлага гарвал, холбогдох JPS салбартай холбоо бариарай.

## Шимтгэл тооцоолох аргачлал

### 1. Танай байгууллагын нийт шимтгэлийг хэрхэн тооцоолох вэ?

Эхлээд, ажилтан тус бүрийн шимтгэлийн хэмжээг, тухайн ажилтны Стандарт сарын цалингийн хэмжээ (SMR) эсвэл Стандарт урамшууллын хэмжээг (SBA)-ийг шимтгэлийн хувь хэмжээгээр үржүүлж, ажилтан тус бүрийн шимтгэлийн дүнг тооцоолно. Тооцооллын нийт дүнгээс нэг иенээс доошхи бутархайг тасалж бүхэлчилсний дараах дүн нь танай ажлын газар, компанийн төлөх эцсийн дүн болно.

Сүүлийн хуудаснаас тооцооллын хүснэгтийн жишээг үзнэ үү.

### 2. Ажилтны шимтгэлийг тооцож, цалингаас суутгах аргачлал

Ажилтны тэтгэврийн даатгал болон эрүүл мэндийн даатгал (EPI/ENI)-ийн ажилтанд ноогдох хувийг тэдний цалингаас суутгана.

Ажилтнаас суутгах шимтгэлийн хэмжээ нь тухайн ажилтны Стандарт сарын цалингийн хэмжээг (SMR) даатгалын шимтгэлийн хувь хэмжээгээр үржүүлж гаргасан дүнгийн тал хувьтай тэнцэнэ.

⇒ Суутгах дүн = Ажиллагсдын Үндсэн сарын цалин (SMR) × Даатгалын шимтгэлийн хувь ÷ 2

Хэрэв тооцооллын үр дүнд 1 иенээс бага үлдэгдэл гарвал, доорх (1) ба (2) дэх тооцооллын дүрмийн дагуу бүхэл тоонд шилжүүлнэ үү.

Сүүлийн хуудаснаас тооцооллын хүснэгтийн жишээг үзнэ үү.

Анхаарна уу 1: Бонусын урамшууллын хувьд, Стандарт сарын цалингийн хэмжээ (SMR)-гийн оронд Стандарт урамшууллын дүн (SBA)-г ашиглан дүнг тооцоолж, бонусаас нь суутгана.

Анхаарна уу 2: Урамшууллаас ажилтны төлөх шимтгэлийн хэсгийг, Стандарт урамшууллын хэмжээг (SBA)-ийг шимтгэлийн хувь хэмжээгээр үржүүлж, үр дүнг хоёрт хуваан тооцоолно. Сарын шимтгэлийг тооцохдоо бэлэн хүснэгт ашиглаж болохгүй.

#### (1) Ажилтны цалин, эсвэл бонус урамшууллаас шимтгэл суутгаж тооцоолох арга

Ажилтны шимтгэлийн хэсгийг тооцоолоход бутархай гарвал, 0.5 иенээс бага буюу тэнцүү бутархай\_таслаж, харин 0.5 иенээс их бутархайг бүхэл тоо руу шилжүүлж тооцно.

Суутгал хийх дүнгийн жишээ:

12,345.50 иен ⇒ 12,345 иен бүхэл болгож хасаж шилжүүлнэ

12,345.51 иен ⇒ 12,346 иен бүхэл болгож нэмж шилжүүлнэ

#### (2) Ажилчнаас бэлэн мөнгөөр авах шимтгэлийн тооцоо

Цалингаас нь суутгах боломжгүй бол, ажилчдын хувийг доорх зааврын дагуу бэлэн мөнгөөр авна:

Ажилтны шимтгэлийн хэсгийг тооцоолоход бутархай гарвал, 0.5 иенээс бага бутархайг хасч тооцно. Харин 0.5 иенээс их буюу тэнцүү бутархайг дараагийн бүхэл иенд дээшлүүлж тооцно.

Бэлнээр мөнгөөр авах тооцооллын жишээ:

12,345.49 иен ⇒ 12,345 иен бүхэл болгож хасаж шилжүүлнэ

12,345.50 иен ⇒ 12,346 иен бүхэл болгож нэмж шилжүүлнэ

Анхаарна уу: Дээрх (1) ба (2) дүрэм үйлчлэхгүй тохиолдолд, ажил олгогч болон ажилтан хоёр шимтгэлийн тооцоонд гарсан бутархайг хэрхэн шийдэх талаар харилцан тохиролцож болно.

### 3. Ажил олгогчийн шимтгэлийг хэрхэн тооцоолох тухай

Ажил олгогчийн төлөх шимтгэл нь компанийн нийт шимтгэлээс (бид танд илгээсэн нэхэмжлэлд заасан) ажилтнуудын хувь хэмжээг (2-р зааврын дагуу тооцсон)-ийг хасч тооцсон дүн байна.

Үндсэн зарчмын хувьд, ажил олгогч нь ажилтны үндсэн сарын цалин (SMR)-ийг шимтгэлийн хувь хэмжээгээр үржүүлж гарсан дүнгийн тал хувийг төлөх үүрэгтэй. Бодит байдал дээр, ажилтан тус бүрийн төлөх хувь хэмжээг тооцоолох үед бутархай тоо гардаг тул ажил олгогчийн төлөх дүн болон ажилтны төлөх нийт дүн заавал тэнцүү байх албагүй. Доорх тооцооллын хүснэгтийн жишээг үзнэ үү.

#### Ажилтны тэтгэврийн даатгал (EPI)-ын шимтгэлийн тооцооны жишээ хүснэгт (дээрх зааврыг тусгасан)

Ажилтны тэтгэврийн даатгал (EPI)-ын 18.3%-ийн шимтгэлийн хувь хэмжээний жишээ хүснэгт

Хэрэв ажилтны тэтгэврийн даатгалын шимтгэлийг сарын цалингаас нь суутгах бол (ажилчидтай тусгай гэрээ байгуулаагүй үед) ажилтны төлөх хэсгийг (нийт шимтгэлийн тал хувь)-ийг бутархайгаар нь тооцно. Энэ үед 0.5 иенээс бага буюу тэнцүү бутархай таслаж, 0.5 иенээс их бутархайг бүхэл тоо руу шилжүүлэн тооцно.

(Нэгж: Иен)

	SMR эсвэл SBA	EPI шимтгэлийн хэмжээ	EPI шимтгэлийн 1 / 2 хэмжээ	Ажилчны хувь хэмжээ (Бүхэлчилсэн)	Ажил олгогчийн хувь хэмжээ
Ажилчин А	110,000	20,130.00	10,065.00	10,065	
Ажилчин В	134,000	24,522.00	12,261.00	12,261	
Ажилчин С	150,000	27,450.00	13,725.00	13,725	
Ажилчин D	118,000	21,594.00	10,797.00	10,797	
Ажилчин E	118,000	21,594.00	10,797.00	10,797	
Ажилчин F	98,000	17,934.00	8,967.00	8,967	
Нийт дүн	728,000	133,224.00	66,612.00	66,612	66,612
Танай компанийн Ажиллагсдын Тэтгэврийн Даатгал(EPI)-ын шимтгэлийн хувь хэмжээ		133224			

Японы Тэтгэврийн Үйлчилгээний Газар (JPS)-ын салбараас танд нийт дүнг бүхэл тоонд шилжүүлсний дараа, гаргасан эцсийн дүнг мэдэгдэнэ.

Ажил олгогчийн шимтгэлийн хэмжээг, шимтгэл төлөх мэдэгдэлд заасан нийт дүнгээс ажилтнуудын төлөх нийт дүнг хасч тооцоолно. (Тооцоололд бутархайг бүхэл тоонд шилжүүлсэн тул ажил олгогчийн шимтгэлийн дүн нь нийт шимтгэлийн яг 50%-тай тэнцэхгүй байх боломжтой.)  
133,224 иен - 66,612 иен = 66,612 иен ... Ажил олгогчийн хувь